

10

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Б.Цэцгээ

Аялал жуулчлалын салбар нь өөрийн цар хүрээ, хөгжлийн хурдаараа эдийн засаг бизнесийн салбар болсноор манай эдийн засгийн залуу тэргүүлэх салбаруудын нэг боллоо. 1990 оноос хойш энэ салбарын хөгжилд шинэ үе эхэлж даяарчлал, мэдээллийн технологийн хөгжил, дэвшил улс орны бие даасан нээлттэй гадаад бодлого манайд аялал жуулчлалыг хөгжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлээ.

Монгол улсын Засгийн газраас ихээхэн хүч чармайлт тавьж 1995-2005 онд аялал жуулчлалыг хөгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлж мастер төлөвлөгөө боловсруулсан ба 2000 онд Аялал жуулчлалын тухай Монгол улсын хуулийг батлан эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Аялал жуулчлалын салбарт хувийн хэвшлийнхэн ихээр орж ирснээр манай аялал жуулчлал эрч хүчээ авсан ба тэдгээрийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн нь салбарыг хөгжүүлэхэд бодит дэмжлэг болж байна. үүний дүнд сүүлийн жилүүдэд монголд зочилж буй гийчид, жуулчдын тоо жил бүр дунджаар 15-20 хувиар нэмэгдэж салбарын орлогын хэмжээ ДНБ-ий 10 орчим хувийг эзлэх боллоо.

Монголд ирж буй гийчид, жуулчдын судалгаа /1997-2002, мян.хүн/

| | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 | Өсөлт |
|--------------------------------|------|-------|-------|-------|-------|-------|-------|
| 1. Гийчид | 82,0 | 197,4 | 158,7 | 158,2 | 192,0 | 230,2 | 1,2 |
| 2. Жуулчид | 82,0 | 165,0 | 137,9 | 137,4 | 165,9 | 198,1 | 1,2 |
| 2.1. Европоос | 25,9 | 62,1 | 65,8 | 61,6 | 80,7 | 90,2 | 1,1 |
| ОХУ | 8,7 | 48,9 | 51,7 | 45,2 | 59,5 | 65,5 | 1,1 |
| Герман | 3,3 | 2,9 | 2,9 | 3,5 | 4,7 | 6,1 | 1,3 |
| 2.2. Ази, Номхон далайн бүсээс | 50,3 | 98,3 | 66,6 | 69,3 | 79,8 | 100,2 | 1,3 |
| Хятад | 32,5 | 80,7 | 48,3 | 49,3 | 57,3 | 74,5 | 1,3 |
| Япон | 11,1 | 11,6 | 10,9 | 10,3 | 10,3 | 12,3 | 1,2 |
| Өмнөд Солонгос | 3,3 | 2,8 | 4,0 | 6,6 | 8,3 | 12,3 | 1,5 |
| 2.3. Америкаас | 5,1 | 4,3 | 4,9 | 5,8 | 6,7 | 6,9 | 1,0 |
| АНУ | 4,3 | 3,6 | 4,4 | 5,2 | 5,8 | 5,7 | -1,0 |
| 2.4. Бусад бүсээс | 0,7 | 0,3 | 0,6 | 0,7 | 0,5 | 0,8 | 1,6 |

Хүснэгтээс харахад гийчдийн тоо 2002 онд 2001 онтой харьцуулахад 19,9%, жуулчдын тоо 19,4%-иар өсч жуулчдын тоо нийт гийчдийн 86,4%-ийг эзэлж байна. Бүтцийн хувьд Европ болон Ази, Номхон далайн бүсийн орнуудаас ирсэн жуулчдын тоо өндөр байна. Тухайлбал, манай хоёр хөрш орнуудаас ирсэн жуулчдын тоо хамгийн их байгаа ба нийт жуулчдын 70,7%-ийг эзэлж байна.

Аялал жуулчлалын салбарын орлого

| | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|------------------------|------|------|------|-------|-------|-------|
| 1 Орлого /сая US\$/ | 12,5 | 32,5 | 27,8 | 26,65 | 102,9 | 130,1 |
| 2 ДНБ-д эзлэх хувь | 1,3 | 3,7 | 2,8 | 2,8 | 10,1 | 9,8 |
| 3 Экспортод эзлэх хувь | 2,7 | 10,2 | 8,2 | 5,7 | 19,7 | 24,8 |

Жуулчдын тоо өсөхийн хэрээр аялал жуулчлалын орлого нэмэгдэн 2002 онд 26,4%-иар өсч ДНБ-ий 9,8%, экспортын 24,8%-ийг тус тус эзэлж байна. Аялал жуулчлалын орлого жуулчдын тооноос хурдан өсч байгаа нь нэг жуулчнаас орж ирж байгаа дундаж орлого түүнчлэн үйлчилгээний чанар үнэ нэмэгдсэнийг харуулж байна. Жуулчдын Монголд байх дундаж хугацаа уртсан 12,8 хоног болж, хоногт зарцуулж буй мөнгөний дундаж хэмжээ 87US\$ байна.

2001 оноос хойшхи жуулчдын тоо, салбарын орлого шинэ журмаар тооцдог болсон хэдий ч аялал жуулчлалын статистик хангалтгүй байна. Аялал жуулчлалын статистикт мэдээллийн бүрэн бүтэн байдал болон зэрэгцүүлэлт нь хамгийн чухал асуудал юм. Аялал жуулчлалыг индустрийн нарийн нийлмэл байдлаас шалтгаалан статистик тооцооны аргачлал боловсронгуй бишээс аялал жуулчлалыг эдийн засгийн түргэн өсөлт болон ажил эрхлэлтийн өндөр түвшинг хангах үйлдвэрлэлийн сектор мэтээр үнэлэхэд төвөгтэй байна. Манайд аялал жуулчлалын үйлчилгээний зах зээлийн үнэлгээний аргачлал байхгүй,

аялал жуулчлалын эдийн засгийн олон улсын стандарт бүхий мэдээлэл үгүйгээс аялал жуулчлалын салбарын эдийн засгийн нөлөөг дутуу үнэлж байна.

1999 онд Дэлхийн аялал жуулчлалын байгууллага аялал жуулчлалын тооцооны шинэ систем болох сателлит тооцоог (Tourism Satellite Account) гаргасан. Энэ нь үндэсний тооцооний системийн хүрээнд үндэсний эдийн засагт аялал жуулчлалын үзүүлэх нийт үр дүнг тодорхойлох боломж олгосон нийлмэл салбаруудын үзүүлэлтүүдийг тооцдог. Иймд олон улсын шаардлага хангасан сателлит тооцооны аргыг нэвтрүүлэх нь манай аялал жуулчлалын статистикийг сайжруулна гэж үзэж байна. 1998 онд TACIS хөтөлбөр, 2002 онд USAID агентлагаас монголд ирсэн зорчигч жуулчдын дунд хийсэн судалгаа нь чухал ач холбогдлоо өгсөн.

Монгол улсын Засгийн газраас 2003 оныг "Монголд зочлох жил" болгон зарласан нь дэлхийн бусад оронд өөрийн орныг сурталчилж таниулахын зэрэгцээгээр улс орны эдийн засагт тодорхой хэмжээгээр нөлөөлөх боломж нэмэгдсэн. үүнтэй холбоотойгоор 170 сая US\$ гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэд бүтцийг хөгжүүлэхэд төлөвлөсний 11 саяыг нь аялал жуулчлалын салбарт зориулах юм.

Манай улсад одоо 470 гаруй аялал ААН аялал жуулчлалын ажил үйлчилгээ үйлчилгээ явуулж байгаагаас гадна 50 орчим гадаадын хөрөнгө оруулалттай ААН ажиллаж байна. Доорх хүснэгтэд аялал жуулчлалын байгууллагуудын бүтээгдэхүүний тооцоог үзүүлэв.

| | 2000 | 2001 |
|----------------------------------|-------|-------|
| 1 Нийт гаргалт | 100,0 | 100,0 |
| 2 Нэмэгдэл өртөг | 23,4 | 23,8 |
| үндсэн ба нэмэгдэл цалин, шагнал | 4,4 | 6,9 |
| үндсэн хөрөнгийн элэгдэл | 2,6 | 3,6 |
| Худалдааны ба онцгой татвар, НӨТ | 4,9 | 1,0 |
| Ердийн ажиллагааны ашиг | 7,3 | 9,3 |
| 3 Завсрын хэрэглээ | 76,6 | 76,2 |
| Тээврийн зардал | 13,1 | 8,1 |
| Ашиглалтын зардал | 7,8 | 3,4 |
| Гадны байгууллагад төлсөн төлбөр | 1,4 | 2,1 |
| Түрээсийн зардал | 2,3 | 1,5 |
| Зочид буудал | 32,9 | 24,5 |
| Хоол | 11,6 | 8,9 |

2001 онд нийт гаргалт 5,1% өссөн. 2000 онтой харьцуулахад ердийн ажиллагааны ашиг нэмэгдсэнээс нэмэгдэл өртөг нэмэгдсэн ба ашиглалтын зардал /жуулчдын унааны хөлс/ буурснаас завсрын хэрэглээ багассантай холбоотой байна. 2001 онд нийт зардлын 47,5%-ийг үйлчилгээний зардалд, 2,8%-ийг орлогын татварт зарцуулсан байна.

Эцэст нь аялал жуулчлалын салбарыг цаашид тогтвортой хөгжүүлэхэд дараах чиглэлүүдэд анхаарах нь зүйтэй гэж дүгнэж байна.

- хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх
- аялал жуулчлалын индустрийг хөгжүүлэх, дэд бүтцийг сайжруулах
- хөрөнгө оруулалтыг дэмжих, түүний ашигтай хуваарилалт
- гааль, татварын хөнгөлөлттэй бодлого
- мэдээллийн автоматжуулсан систем байгуулан зар сурталчилгаа мэдээллийн хангамжийг сайжруулах
- үндэсний тооцооны системийн хүрээнд сателлит тооцооны аргыг нэвтрүүлэх
- үйлчилгээний чанар, өрсөлдөх чадварыг сайжруулж олон улсын жишигт хүргэх, үйлдвэрлэлийн зардлыг бууруулах
- чанар, үр ашигтай хуваарилалтыг нь дээшлүүлснээр аялал жуулчлалын нөөцийн тэнцвэрийг дээшлүүлэх
- улирлын чанарыг багасгах
- чадварлаг боловсон хүчин бэлтгэх хэрэгтэй юм.